

БНХАУ, АСЕАН-Ы ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Н.Төмөр**

БНХАУ, Зүүн өмнөд Азийн орнуудын хооронд улс төр, эдийн засгийн харилцаа сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц идэвхжин хөгжиж ирсэн. 1991 оны долдугаар сард болсон АСЕАН-ы орнуудын ГЯЯ-ны сайд нарын чуулга уулзалтад анх удаа БНХАУ-ын ГЯЯ-ны сайд уригдаж оролцсоноор Хятад улс, АСЕАН-ы хооронд яриа хэлэлцээний түншийн харилцаа тогтоожээ. БНХАУ-ын дарга асан Зян Земинь 1997 оны арванхоёрдугаар сард Куала-Лумпурт айлчлан, АСЕАН-ы орнуудын төрийн тэргүүн нартай уулзаж, тэдгээр орнуудтай хамтран ажиллах талаар тохиролцон улмаар “Хятад Улс ба АСЕАН-ы орнуудын төрийн тэргүүн нарын уулзалтын хамтарсан мэдэгдэл” гарган “АСЕАН+1” механизмыг бий болгожээ.¹ БНХАУ болон АСЕАН-ы орнуудын удирдагчид тус бүс нутаг болон өөрийн улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө эрх тэгш харилцан ашигтай байх үндсэн дээр хоёр талын болон олон талын хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд тус дөхөм үзүүлэн, “Хятад улс-АСЕАН-ы хамтын ажиллагааны хамтарсан хороо”, “Хятад улс-АСЕАН-ы эдийн засаг, худалдааны хамтарсан хороо”, “Хятад улс-АСЕАН-ы шинжлэх ухаан технологийн хамтарсан хороо” зэрэг байгууллагаар дамжин хамтын ажиллагаагаа цаашид бэхжүүлэн хөгжүүлэхээр тохиролцжээ. 2003 оны аравдугаар сард Хятад улс “Зүүн өмнөд Азийн найрамдал хамтын ажиллагааны гэрээ”-нд нэгдэн орсон.

Зүүн Азийн бүс нутгийн хамтын ажиллагааг өрнүүлэх нэгэн шинэ механизм болох “АСЕАН+3” 1997 оны арванхоёрдугаар сард Куала-Лумпурт болсон АСЕАН-ы дээд хэмжээний албан бус уулзалтын үед эхлэлээ тавьсан.² Тэр үед АСЕАН-ы 10 улсын төр засгийн дээд хэмжээний уулзалтад БНХАУ, Япон, БНСУ-ын удирдагчдыг урьж оролцуулан, хамтарсан хуралдаан дээр эдийн засаг, худалдааны талаар хамтран ажиллахаар ярилцан тохиролцсоноор “АСЕАН+3” механизмыг байгуулсан. “АСЕАН+3” механизм байгуулагдсанаас хойш олон чухал санал санаачилга дэвшүүлэн хэрэгжүүлсэн билээ.

БНСУ-ын Ерөнхийлөгчийн Ро Му Хений санаачилгаар “АСЕАН+3”-ын удирдагчид тохиролцон шийдэж, Зүүн Азийн хэтийн төлвийн групп /East Asia Vision Group/, Зүүн Азийг судлах групп /East Asia Study Group/-ыг 1998, 2000 онд тус тус байгуулан ажиллуулав. “Зүүн Азийн хэтийн төлвийн групп” санхүү, эдийн засгийн хамтын ажиллагаанаас гадна, улс төр, аюулгүй байдал, байгаль орчныг

* Н.Төмөр - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хамгаалах, эрчим хүч, соёл, шинжлэх ухаан зэрэг салбарыг хамарсан нийт 26 хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулжээ. Эдгээр төслөөс Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс /ЕАФТА/, Зүүн Азийн хөрөнгө оруулалтын бүс /ЕАИА/ байгуулах төсөл нь тус бүс нутгийн эдийн засаг, худалдааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

2010 онд байгуулагдаж дуусах Хятад улс-АСЕАН-ы орнуудын худалдааны чөлөөт бүс нь дэлхийн томоохон худалдааны чөлөөт бүсүүдийн нэг болох бөгөөд энэхүү бүсийг байгуулах санаачлагыг 2001 оны арваннэгдүгээр сард Брунейд болсон АСЕАН-Хятадын удирдагчдын 5 дахь удаагийн чуулга уулзалт дээр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд асан Жу Рунзи анх тавьсан. Энэхүү худалдааны чөлөөт бүс нь 2 тэрбум хүн амтай, 14 сая хавтгай дөрвөлжин км талбайтай байх бөгөөд ДНБ 4-5 мянган тэрбум ам.долларт хүрнэ гэж хятадын эрдэмтэд бичжээ.³

БНХАУ АСЕАН-ы орнуудтай улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны найрсаг харилцааг бэхжүүлэн хөгжүүлэхэд ямагт анхаарал тавьж, Хятадын төрийн тэргүүн Ян Шанкунь, Зян Земинь, Ху Жинтао, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн, Жу Рунзи, Вэнь Зябао нар АСЕАН-ы орон болох Бүгд Найрамдах Сингапур Улс, Малайз Улс, Бүгд Найрамдах Индонез Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Филиппин Улс, Камбожийн Вант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Мьянмарийн Холбооны Улс, Бруней Даруссалам Улс, Тайландын Вант Улс зэрэг улсад төрийн болон албан ёсны найрсаг айлчлал удаа дараа хийж байсан нь үүнийг харуулав. 1991 оноос хойш Хятад улс, АСЕАН-ы орнуудын хооронд хийсэн худалдааны хэмжээ тасралтгүй өсөж, “1990 оны байдлаар эдгээр орнуудтай нийт 6.69 тэрбум ам.долларын худалдаа хийсэн бол 2004 онд энэ тоо 105.88 тэрбум ам.долларт хүрсэн буюу БНХАУ-ын гадаад худалдааны нийт хэмжээний 9.17%-ийг эзлэв” гэж Хятадын Гаалийн газраас мэдээлжээ.⁴ АСЕАН-ы орнуудаас Хятад улс мод, газрын тос, байгалийн хий, нүүрс, түүхий каучук зэрэг түүхий эдээс гадна электрон бараа авч, оронд нь сүлжмэл бүтээгдэхүүн, бэлэн хувцас, гутал, хүнсний бүтээгдэхүүн, будаа тариа, барилгын материал, цахилгаан бараа, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн зэрэг аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлсээр ирлээ.

БНХАУ, АСЕАН-ы орнуудтай гадаад худалдааны үйл ажиллагааг өрнүүлэхээс гадна эдийн засгийн өөр бусад хэлбэрийн хамтын ажиллагааг мөн эрчимтэй өрнүүлж байна. Тухайлбал, эдгээр орнуудад 2005 оны сүүлийн байдлаар Хятад улс нийт 1,08 тэрбум ам.долларын хөрөнгө оруулжээ. Үүнд: Камбожид бэлэн хувцасны үйлдвэр, Бирмийн усан цахилгаан станц, Лаосын цементийн үйлдвэр, Вьетнамын мотоциклын үйлдвэр, Хөдөө аж ахуйн машин механизмын үйлдвэр, Тайландын сүлжмэлийн үйлдвэр зэрэг барилга байгууламж барьж байгуулахад тус тус зарцуулагджээ. Харин АСЕАН-ы орнуудаас 2004 оны байдлаар

БНХАУ-д нийт 72,32 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан бөгөөд энэ нь Хятадын гадаад хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 6,6%-ийг эзлэв. Гадаад орнуудаас Зүүн өмнөд Азийн орнуудад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээгээр Хятад улс одоогийн байдлаар тэргүүний байр эзэлж чадахгүй байгаа бөгөөд тэрээр зөвхөн өөртөө нэн хэрэгтэй эрчим хүчний болон түүхий эдийг олборлох чиглэлээр тэдгээр орнуудад хөрөнгө оруулах сонирхолтой. Зүүн өмнөд Азийн орнуудын хувьд сэргэн хөгжиж буй Хятад улстай эдийн засгаар харилцах харилцааны шинэ хэлбэрийг буй болгох шаардлагатай гэж гадаадын эрдэмтэн судлаачид үздэг.

БНХАУ ба БНСВУ хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр тогтвортой хөгжиж байна. Хоёр орны өндөр түвшинд хүрсэн улс төрийн харилцааг эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаар улам баталгаажуулж байдаг бөгөөд БНХАУ, БНСВУ-ын бүх талын харилцааг тогтвортой хөгжүүлэх явдлыг гүнзгийрүүлэхэд дээд, өндөр хэмжээний харилцан айлчлал, уулзалт чухал ач холбогдолтой. БНСВУ-ын Ерөнхийлөгч Nguyen Minh Triet 2007 оны тавдугаар сард БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Тэрээр айлчлалынхаа үеэр БНХАУ-ын дарга Ху Жинтаотой албан ёсны хэлэлцээ хийж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, хоёр талын худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл боловсрол, шинжлэх ухаан, техникийн болон бусад салбар дахь хамтын ажиллагааг цаашид эрчимжүүлэн хөгжүүлэх талаар ярилцав.⁵ 2006 онд хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа амжилттай явагдаж, гадаад худалдааны хэмжээ 9.95 тэрбум ам.долларт хүрэв гэж БНХАУ-ын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч мэдэгджээ.⁶

Хятад улс болон Зүүн өмнөд Азийн орнууд аль аль нь аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц баялгаар арвин учраас тэдгээр улс орнуудын хооронд энэ чиглэлээр хамтран ажиллах бүрэн бололцоотой билээ. 2003 оны наймдугаар сард Бээжин хотноо хуралдсан БНХАУ, Япон улс, БНСУ болон АСЕАН-ы орнуудын Аялал жуулчлалын яамдын сайд нарын хурлаас “10+3 аялал жуулчлалыг сэргээн хөгжүүлэх Бээжингийн тунхаглал” гаргажээ. Сүүлийн жилүүдэд БНХАУ, АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны нэгэн чухал хэсэг нь аялал жуулчлалын хамтын ажиллагаа болж, 2005 оны байдлаар Хятадын 3 сая гаруй жуулчид Зүүн өмнөд Азийн орнуудаар аялж, ялангуяа Сингапур, Малайз, Тайланд зэрэг улс нь тэдний алтан маршрут болсон.

АСЕАН-ы орнуудтай эдийн засгийн харилцааг цаашид улам эрчимтэй хөгжүүлэх нь БНХАУ-ын ашиг сонирхолд нийцнэ. Зүүн өмнөд Азийн эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал нь Гонконг, Макаогийн тогтвортой байдал ба хөгжил цэцэглэлтэд шууд нөлөөлөхөөс гадна Хятадын эдийн засгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж буй тус улсын тэнгисийн эргийн муж нутгийн эдийн засгийн

хөгжлийн хурдад ч нөлөөлөх юм. Ялангуяа эдийн засгийн даяаршлын өнөөгийн үед SARS, шувууны томуу зэрэг уламжлалт бус аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардагдах бөгөөд нэг үгээр хэлбэл, Хятад улсын эдийн засгийн хөгжилд Зүүн өмнөд Азийн орнууд чухал үүрэг гүйцэтгэж байна. Зүүн өмнөд Азийн орнууд нь Азид хамгийн их байгалийн нөөц баялагтай бүс нутгийн нэг бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох тутарга, каучук, дал модны тосны үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг байхаас гадна, Хятадын эдийн засгийг хөгжүүлэхэд нэн ихээр шаардагдах газрын тос, байгалийн хийн нөөц Индонезид их байдаг. Хятад улсын импортын газрын тосны 70%-ийг Малайн хойг, Индонезийн Суматр арлын хооронд оршдог Малаккийн хоолойгоор дамжин орж ирдэг бөгөөд 2010 он гэхэд энэ хоолойгоор жилд дунджаар 200 сая газрын тос авах төлөвтэй гэж хятадын эрдэмтэд тооцоолжээ.

Хятад, Бирм, Тайланд, Лаос, Вьетнам, Камбож зэрэг 6 улс Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 1992 онд байгуулсан “Их Меконг мөрний орчим нутгийн хамтын ажиллагааны байгууллага” нь БНХАУ-тай Зүүн өмнөд Азийн орнууд эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ачаа тээвэр, эрчим хүч, байгалийн нөөц баялаг, хөдөө аж ахуй, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, харилцаа холбоо зэрэг чиглэлээр хамтран ажилладаг билээ. Хятад улс энэхүү байгууллагын ажиллагаанд идэвхтэй оролцон тухайлбал, 2002 оны арваннэгдүгээр сард Камбожийн нийслэл Пномпень хотноо болсон Их Меконг мөрний орчим нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны удирдагчдын чуулга уулзалтад Хятадын төлөөлөгчид оролцон тус бүс нутгийн хамтын ажиллагааны чухал объектын нэг болох Хятадын Куньмин, Тайландын Бангкок хоёр хотыг холбох авто замыг барьж байгуулахад хүүгүй зээл олгон хөрөнгө оруулахаар шийдвэрлэжээ. Ийнхүү БНХАУ, АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж байгаа явдал тухайн орнуудын нийгэм эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлөхөөс гадна Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдал, эдийн засгийн хөгжилд ч мөн тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ:

1. “Joint Statement of the ASEAN-China Leaders Meeting”, Kuala-Lumpur, 16 December 1997
2. “Peace and Security in East Asia”, Beijing, 2005. p.148
3. “Around Southeast Asia”, 2006. No 10, p.6
4. Мөн сэтгүүл, p.3
5. “Жэньминь жибао”, 2007.05.17, <http://english.vietnamnet.cn>
“President Triet’s China visit, new momentum for relationship”.
6. <http://www.news.xinhuanet.com>, 2007.05.15